

**ЧИНГИС ХААНЫ МЕНЕЖМЕНТИЙН ХОЛБОО**

**ОЛОН УЛС СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛЬ**  
*The Institute of International Studies*

**“Чингис Хаан  
Судлал”-ын үндэсний  
анхдугаар симпозиумын  
материалууд**



**Улаанбаатар 2008**

**“ЧИНГИС ХААН СУДЛАЛ”- ын  
ҮНДЭСНИЙ АНХДУГААР СИМПОЗИУМ**

Хэл шинжлэлийн шинжлэх ухааны доктор /Sc.D/, профессор.  
Б. Сумъяабаатар - /ШУА, Хэл Зохиолын Хүрээлэн/

**“ Чингис хаан ба Өгөөдэй хааны зарлигуудыг  
зэрэгцүүлэн судалсан дүнгээс”**

Улаанбаатар.  
2008. 02. 04

## Чингис хаан ба Өгөөдэй хааны зарлигуудыг зэргэцүүлэн судалсан дүнгээс

Б.Сумьяабаатар (Монгол)

- Юань (Юань, 元 yuán) гэдэг нэрийн учир
- Монголын Нууц Товчоо хэдэн үгтэй вэ?
- Чингис хаан ба Өгөөдэй хааны зарлигуудыг зэргэцүүлэн судалсан дүнгээс
- Нууц Товчооны зохиогч хэн байж болох вэ?

01. Чингис хаан судлал, Нууц Товчоо судлал хоёр бол хүйн холбоотой, салгаяа хэмээвч санаснаар үл болох төрөлхи барилдлагат ухаан. Түүний дотроос, Монголын Нууц Товчоо бичмэл эхтэй, машид боловсорсон, бичгийн ба аманбичгийн хэлний яруу найруулгатай, өмнөө их ундаргатай, хойноо олон дагуултай оргил бүтээл. Нууц Товчоог анх туурвихдаа, ямар нэгэн бичмэл эхэд дулдуйдсаныг батлах жишээ олон. Үүнд: Монголын Нууц Товчоог энд тэндээс сураглан түүвэрлэж эвлүүлээгүй, бичгийн эхийг баримтлан бичсэн гэдгийг Нууц Товчооны эхний удам судрын хэсэг, Чингис хаан ба Өгөөдэй хааны зарлигууд хөдөлгөөнгүй баталж өгнө.

Чингис хааны узуурыг гаргасан хэсэг л гэхэд 24 үеийн хэдэн арван хүний удам угсааг тэмдэглэжээ. Тэмдэглэх тэмдэглэхдээ, нэг айлын тэргүүлсэн, дунд, бага хөвүүдийн дэс дарааг алдуулаагүй. Ахмад буюу тэргүүлсэн хөвүүнийг зүүн гар талд бичээд, түүний салаа салбаруудыг алдалгүй бичсэн байх нь, явчиг санаан зоргоор үйлдсэн бус, ямар нэгэн бичгийн эхийг харж байгаад нягт нямбай хуулсан шинж төгс харагдана. Хорь гаруй үеийн, тийм олон салаа салбар болсон хүмүүсийг гэргий, зарц, хөлөг морьд, үйл явдал болсон газар орны нэрийн хамтаар цээж мэддэг хүн байсан гэхэд хүүхэд ч итгэхгүй. Мөн Нууц Товчооноо олон хүний цолыг тэмдэглэсэн байх ба түүнийг юу ч харалгүй, дураар зохиосон хэмээн үзэх нь, ухаант хүний санаанд орж, амнаас гарч, гараар бичих зүйл хэрхэвч биш. Энд, элбэгийг нь “баян”, мэдэлтнийг нь “хаан”, эзэмшилтэйг нь “хан”, эрэлхэгийг нь “баатар”, бардмыг нь “догшин”, оночитойг нь “мэргэн”, ухаантайг нь “сэцэн”, түшлэгтэйг нь “ноён”, үзэсгэлэнтэйг нь “гоо” гэх зэргээр цоллож бичжээ. Энэ мэт, Нууц Товчооноос өмнө монголчуудад “Узуурын бичиг” гэсэн бичмэл дэвтэр байсан байна гэж баттай хэлэх үндэстэй. Тэр нь одооныхоор бол Угийн бичиг юм.

Мөн, Чингис хаан ба Шиги Хутугу хоёрын зөтөлдэж (vii-203-39) бичиж үлдээсэн “Хөх дэвтэр” хэмээх

цааз эрхэмжийн бичиг байсан нь үгүйсгэшгүй баримттайгаас гадна, Нууц Товчоон дахь төсөөт хэллэгүүдийг зэргэцүүлэн судлах явцад улам тодорч байна.

02. Болсон явдал, хэлж ярьсан зүйлийг бас бус газар, өөр өөр цагт, элдэв нөхцөл байдалд дахин давтан өгүүлсэн зүйл Нууц Товчоонд олонтаа тохиолдоно. Түрүүчийнхтэйгээ хэрхэн таарч, мөн юугаараа зөрж байгааг нарийвчлан судалвал, Нууц Товчоог анх туурвихдаа, ямар нэгэн бичмэл эхэд түшиглэсэн болохыг бид аандаа мэдэрч, Нууц Товчооны бичлэгийн аргын талаар сонин сэвүүн юмыг ажиглах болно.

□ “Мөнх Тэнгэр” гэдэг хэллэгээр жишээ авъя.

“Мөнх Тэнгэр” гэдэг хэллэгийг анх хэрэглэсэн хүн бол Тэмүүжин байна. Тэрбээр, Чингис хаанд өргөмжлөгдөхөөсөө урьд буюу 1206 оны барс жилээс өмнө хэлжээ. Үүнийг, 1202 оны нохой жилээс хойш, 1204 оны хулгана жилээс урагш гэж тогтоож байна. Хээр газар хэлсэн. Хэлсэн газар нь Мау Өндөр (нан. 勿溫都兒 мон.  $\text{ᠮᠠᠤ ᠥᠨᠳᠦᠷ}$ ) Улаан Бургад (нан. 忽剌安不魯魯合魯 мон.  $\text{ᠬᠡᠯᠠᠭᠠᠨ ᠪᠦᠷᠭᠠᠳ}$ ) хавьд болно. Ван хантай ширүүн байлдаж, орой болж, зайлж хоноод, бүртгэж үзвээс Өгөөдэй, Борухул, Боорчи нар үгүй байсан. Боорчийг эргэж ирсний хойно, хүү Өгөөдэй эс ирсэнд, Тэмүүжин “Мөнх Тэнгэр мэдтүгэй” гэж хэлсэн байдаг (МНТ. VI-172-11).

Үүнээс хойш, “Мөнх Тэнгэр” гэдэг ойлголт ямар замыг туулж, хэрхэн өргөжин тэлсээр, баяжин төгөлдөржсөөр “Мөнх Тэнгэрийн хүчиндор Хааны суудор” гэсэн монгол Гадаад харилцааны бичгийн манлай үг  $\text{ᠮᠡᠨᠬᠡ ᠲᠡᠩᠭᠡᠷ ᠮᠡᠳᠲᠦᠭᠡᠢ}$  болсныг доорх жишээ харуулна :

(Чингис хааны үг) Мөнх Тэнгэр мэдтүгэй (VI-172-11)

(Чингис хааны үг) Мөнх Тэнгэр чи мэд (XII-265-44)

(Чингис хааны үг) Мөнх Тэнгэрийг залбирч (X-240-13)

(Чингис хааны үг) Мөнх Тэнгэрт ихээгдэж (ивээгдэж) (VII-187-11, VIII-203-25, XII-265-30)

(Чингис хааны үг) Мөнх Тэнгэрт ихээгдвээс (ивээгдвээс) (XI-256-12)

(Чингис хааны үг) Мөнх Тэнгэрт хүч нэмэгдэж (XII-267-20)

(Чингис хааны үг) Мөнх Тэнгэрт хүч аугаа нэмэгдэж (VIII-199-36)

ᠮᠥᠨᠬᠡ ᠲᠡᠩᠭᠡᠷᠲᠡ ᠬᠦᠴᠢ ᠠᠭᠤᠭᠠᠨ ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠵᠢ

(Чингис хааны үг) Мөнх Тэнгэрт үүдэн жолоо нээгдэв зээ (VIII-208-9)

ᠮᠥᠨᠬᠡ ᠲᠡᠩᠭᠡᠷᠲᠡ ᠦᠦᠳᠡᠨ ᠵᠣᠯᠤᠭᠠᠨ ᠨᠡᠭᠡᠭᠳᠡᠵᠢ

(Тэв Тэнгэрийн үг) Мөнх Тэнгэрийн зарлиг (X-244-12)

ᠮᠥᠨᠬᠡ ᠲᠡᠩᠭᠡᠷᠡᠶᠢᠨ ᠵᠢᠷᠯᠢᠭ

(Чингис хааны үг) Мөнх Тэнгэрийн хүчиндөр Тэнгэр газараа (газарт) хүч аугаа нэмэгдэж (IX-224-8)

ᠮᠥᠨᠬᠡ ᠲᠡᠩᠭᠡᠷᠡᠶᠢᠨ ᠬᠦᠴᠢᠨᠳᠦᠷ ᠲᠡᠩᠭᠡᠷ ᠭᠠᠵᠢᠷᠠᠭᠠᠨ (ᠭᠠᠵᠢᠷᠲᠡ) ᠬᠦᠴᠢ ᠠᠭᠤᠭᠠᠨ ᠨᠡᠮᠡᠭᠳᠡᠵᠢ

(Бат ханы үг) Мөнх Тэнгэрийн хүчиндөр Хаан авгын суудор (XII-275-2) болно.

ᠮᠥᠨᠬᠡ ᠲᠡᠩᠭᠡᠷᠡᠶᠢᠨ ᠬᠦᠴᠢᠨᠳᠦᠷ ᠬᠠᠭᠠᠨ ᠠᠪᠭᠢᠨ ᠰᠤᠭᠤᠳᠣᠷ

Ингэхэд, Чингис хааны үед бичиж тэмдэглэсэн зүйлс ба Өгөөдэй хааны үед бичиж тэмдэглэсэн зүйлс агуулга адил боловч хоорондоо үг үсэг, дагавар нөхцөлийн талаар зөрөөтэй, үг хэллэг, өгүүлбэр нь хойно урдаа орсон, найруулгын талын ялгаа гарч байна. Энэ нь, 13-р зууны эхэн үе буюу 1206 оны Барс жил орчмын монгол бичгийн хэл ба 13-р зууны дунд үе, тухайлбал, Нууц Товчоо зохиох үеийн монгол бичгийн хэлний өөрчлөлт хувьслыг харуулах тул, бидэнд тун хэрэгтэй, ховор нандин баримт мөн.

Эл судалгааны эхийг бид тавив. Цааш цаашдаа гүнзгийрүүлэн судлах нь юу юунаас чухал бөгөөд, тэр нь Нууц Товчоо судлалд шинэ алхам, Нууц Товчоо судлалын шинэ салбар болох учиртай. Мөн энэ нь, Нууц Товчоог бичмэл эхэд дулдуйдан зохиосон гэдгийг батлахын зэрэгцээ, Нууц Товчооны зохиогчийг тодруулах хийгээд, Нууц Товчооны бичлэгийн цаг үе, орон зай, орчин нөхцөл, аман ба бичгийн хэлний хөгжил хувьслыг судлахад туйлаас чухал, сонин сэвүүн хэрэглэгдэхүүн юм. Харин түүнийг, агуулга ижил зүйл дээр авч үзэх ёстой. Тэр нь, хэд хэд давтагдаж буй зүйр сэцэн үгс, хэвшмэл хэллэг, ерөөл магтаал, аялга үг, хууль эрхэмж, засаг цаазын зүйлд нэлээд байгааг дэлгэр жишээгээр харуулая :

② Өөр нэг жишээ авъя :

1. (Энэ хөвүүн чинь) Нүдэндээ галт Нүүртээ гэрэт хөвүүн буй (Дэ Сэцэний үг. I-62-5)

ᠨᠦᠳᠡᠨᠳᠡᠭᠡ ᠭᠠᠯᠲᠤ ᠨᠡᠭᠦᠷᠲᠡᠭᠡ ᠭᠡᠷᠡᠲᠡ ᠬᠥᠪᠦᠭᠦᠨ ᠪᠤᠢ

2. (Охи инү үзвээс) Нүүртээ гэрэтэй Нүдэндээ галтай охиныг үзэж (Есүхэй Баатарын бодол. I-66-1)

ᠨᠡᠭᠦᠷᠲᠡᠭᠡ ᠭᠡᠷᠡᠲᠡᠢ ᠨᠦᠳᠡᠨᠳᠡᠭᠡ ᠭᠠᠯᠲᠠᠢ ᠣᠬᠢᠨᠢᠭᠢᠭᠡ ᠦᠵᠡᠵᠢ

3. (Тэмүүжинг)

Нүдэндээ галт

ᠨᠦᠳᠡᠨᠳᠡᠭᠡ ᠭᠠᠯᠲᠤ

Нүүртээ гэрэт (Сорхан Шарын үг II-82-6)

ᠨᠡᠦᠷᠲᠡᠭᠡ ᠭᠡᠷᠡᠲᠤ

4. (Тэмүүжинг)

Нүдэндээ галт

ᠨᠦᠳᠡᠨᠳᠡᠭᠡ ᠭᠠᠯᠲᠤ

Нүүртээ гэрэт (Тархудай Хирилтугийн үг V-149-23)

ᠨᠡᠦᠷᠲᠡᠭᠡ ᠭᠡᠷᠡᠲᠤ

∴ Монгол ардын аманзохиол, бичиг сударт олонт гардаг “нүүрэндээ галтай, нүдэндээ цогтой” гэсэн хэллэг Нууц Товчоонд жаахан ялгаатайгаар дөрвөнт гарна. Үүнд, Дэ Сэцэн, Сорхан Шар, Тархудай Хирилтуг нар, Тэмүүжинг “нүдэндээ галт, нүүртээ гэрэт [нан.格<sup>ᠨᠡᠦᠷᠲᠡᠭᠡ</sup>列<sup>ᠭᠡᠷᠡᠲᠤ</sup> = гэрэлт] хөвүүн” гэсэн бол, Йэсүхэй баатар

Бөргийг “нүүртээ гэрэтэй [нан.格<sup>ᠨᠡᠦᠷᠲᠡᠭᠡ</sup>列<sup>ᠭᠡᠷᠡᠲᠤ</sup> мон. ᠨᠡᠦᠷᠲᠡᠭᠡ = гэрэлтэй] нүдэндээ галтай охин” гэсэн байна. Дэ Сэцэн, Сорхан Шар, Тархудай Хирилтуг нарын үгнээ “нүдэндээ” гэдэг үг нь эхэндээ, “галт” гэдэг үгтэй холбоотой байгаа бол, Йэсүхэй баатрын үгнээ “нүүртээ” гэдэг үг нь эхэндээ, “гэрэтэй” гэсэн үгтэй

холбоотой, өөрөөр хэлбэл, үгсийн байр солигдсон, “-ту, -тү” ( нан. 禿 禿 )ийн оронд “-тай, -тэй”

(нан. 台 мон. 禿 ) нөхцөл бичсэн төдий л ялгаа байна. Энэ үгийг Дэ Сэцэн Тэмүүжинг 9 настайд нь, Сорхан Шар залуу насных нь үед, Тархудай Хирилтуг идэр насных нь үед хэлсэн гэж бодоход (Нууц Товчооноо нэг дор биш, өөр өөр зөхмэлтэд гарна), үүнийг мөн л урьд нэгэнт тэмдэглэсэн зүйлээс хуулж Нууц Товчоонд

оруулсан гэж үзэлтэй. Нууц Товчоонд монгол хэлний “гэрэ-” язгуурт “гэрэл” ( 禿 98-2), “гэрэт”

( 禿 62-5,82-6,149-23), “гэрэтэй” ( 禿 66-1), “гэрэтэн” ( 禿 гэрэлтэн 189-25) гэсэн дөрвөн үг (үгийн хэлбэр) зургаантаа гарна...

[3] Одоо, хорчин турхагууд хэрхэн хэшиг орох тухай Чингис хааны зарлиг ба Өгөөдэй хааны зарлигийг дэлгэрэнгүй зэргэцүүлэн үзье. Эндээс бид, Нууц Товчоонд гардаг үйл явдлууд ямар нэгэн бичмэл эхтэй байсан гэдэгт бат итгэх болно.

1. (Чингис хааны зарлиг) Хорчин Турхагууд хэшиг орж (IX-229-2,3)

ᠬᠣᠷᠴᠢᠨ ᠲᠤᠷᠬᠠᠭᠤᠳᠤ ᠬᠡᠰᠢᠭ ᠣᠷᠵᠢ

2. (Өгөөдэй хааны зарлиг) Хорчин Турхагууд урьд ёсоор (XII-278-6)

ᠬᠣᠷᠴᠢᠨ ᠲᠤᠷᠬᠠᠭᠤᠳᠤ ᠤᠷᠦᠳᠤ ᠶᠡᠰᠣᠣᠷ

∴ Чингис хааны зарлигт “хэшиг орж” гэсэн хэллэг байхад, Өгөөдэй хааны зарлигт байхгүй, оронд нь “урьд ёсоор” гэсэн хэллэг оруулжээ. Бусад нь таарч байна.

1. (Чингис хааны зарлиг) өдрийн явдал зүг зүг мөр мөртөөн явж (IX-229-3,4)

ᠥᠳᠦᠷᠢᠶᠢᠨ ᠶᠠᠪᠳᠠᠯ ᠵᠦᠭ ᠵᠦᠭ ᠮᠣᠷ ᠮᠣᠷᠲᠡᠭᠦᠨ ᠶᠠᠶᠢᠵᠢ

2. (Өгөөдэй хааны зарлиг) өдөр мөр мөртөөн явж (XII-278-7)

∴ Чингис хааны зарлигт “өдрийн яедал зүг зүг” гэсэн хэллэг байхад, Өгөөдэй хааны зарлигт байхгүй, зөвхөн “өдөр” гэсэн үг байна. Бусад нь таарч байна.

1. (Чингис хааны зарлиг) нарны галтайяа хэвтүүлээ зайлж (IX-229-4)
2. (Өгөөдэй хааны зарлиг) нартайяа хэвтүүлээ зайлж (XII-278-7,8)

∴ Чингис хааны зарлигт “нарны галтайяа” гэсэн хэллэг байхад, Өгөөдэй хааны зарлигт зөвхөн “нартайяа” гэсэн ойролцоо үгээр төлөөлүүлжээ. Бусад нь таарч байна.

1. (Чингис хааны зарлиг) гадна гарч хонотугай (IX-229-4,5).
2. (Өгөөдэй хааны зарлиг) гадна хонотугай (XII-278-8).

∴ Чингис хааны зарлигт “гадна гарч” гэсэн байхад, Өгөөдэй хааны зарлигт “гарч” гэсэн үг нь байхгүй. Бусад нь таарч байна.

1. (Чингис хааны зарлиг) Хорчин хор, буурчин аяга сав хэвтүүлээ таулж (IX-229-6) одтугай. Гадна хоногсод хорчин, турхагууд, буурчин (IX-229-7) биднийг шөлөн идтэл хирүгэд сууж хэвтүүлд (IX-229-8) хэлчилж шөлөн идэн барваас хорчин хорд (IX-229-9), турхаг сууриндаан, буурчин аяга савдаа (IX-229-10) дайралдтугай. Хэшиг хэшиг орохун мөн мөн (IX-229-11) ёсоор энэ хуулиар тийн хийтүгэй (IX-229-12).

∴ Үдэш болж, Хорчин, буурчин гадагш гарч хонохоор явахдаа хор, аяга саваа хэрхэх, өглөө ирж албандаа хэрхэн орох тухай нарийн заасан Чингис хааны зарлигийн энэ хэсэг Өгөөдэй хааны зарлигт үгүй байна.

1. (Чингис хааны зарлиг) Наран шингэсний хойно ордын (IX-229-13) хойноохун уридаахун хэдгэлзэн явах хүмүүнийг барьж (IX-229-14) хэвтүүл барьж хонож, манагарыг

хэвтүүл үгэс (IX-229-15) инү асагтугай.

2. (Өгөөдэй хааны зарлиг) Үүдэнд (XII-278-9), гэрийн орчин хэвтүүл байтугай. Ордын хойноохун (XII-278-10) уридаахун хэвтүүл мохуритугай. Наран шингэсний хойно (XII-278-11) шөнө явхун аран хэвтүүл барьж хонотугай.

1. Дээрх хоёр зарлигийн үндсэн санаа нь таарч байна. Чингис хааны зарлигийн энэ хэсэгт байхгүй (дараачийн хэсэгт буй) “Үүдэнд, гэрийн орчин хэвтүүл байтугай” гэсэн хэллэг энд орсон; Чингис хааны зарлиг дахь “манагар хэвтүүл үгэс инү асагтугай” гэж, барьж хоносон хүнийхээ үг өчгий нь авах тухайт хэллэг, “хэдгэлзэн” гэдэг үг байхгүй; “мохуритугай”, “шөнө” гэдэг үгс нэмэгдсэн; Чингис хааны зарлигт “нар шингэсэн хойно... явах хүмүүний” гэж, “шөнө болоогүй ч нар л шингэсэн бол сэлгүүцэн явсан хэнийг ч болов, хэвтүүл барьж хоно” гэсэн маш хатуу цааз байгаа бол, Өгөөдэй хааны зарлигт “шөнө явхун аран” гэж өөрчилсөн нь, нар шингэсэн ч шөнө болоогүй бол барихгүй, эрх мэдэл бүхүй хүнийг бол барихгүй, “харц ард, энгийн иргэн” ийг л барина гэсэн санаатай болжээ. Мөн зарим дагавар(-ху, -хун), үгсийн байр солигдсон ялгаа байна.

1. (Чингис хааны зарлиг) Хэвтүүл, хэшиг егүүтгэлдрүүн (IX-229-16) бэлгэ ану таулж орж иртүгэй.

Егүүтгэж (IX-229-17) гархун хэвтүүл таулж-хүү гарч одтугай (IX-229-18)

1. Хэшиг халалцуулах тухай Чингис хааны энэ зарлиг Өгөөдэй хааныхад үгүй байна. Чингис хааны үед хэшиг халалцах журам маш нарийн байжээ. Энд гарч буй “бэлгэ ану таулж” гэдэг хэллэг түүнийг батлана. “бэлгэ” гэдэг нь, үнэхээр халаа авах ёстой хэшиг хүн гэдгийг батлах нууц тэмдэг.

“таулж” гэдэг нь “хүлээлцүүлэх” гэсэн үг. Энэ нь одооныхоор бол, манаа халалцах үеийн нууц үг ба нууц таних тэмдгийг хэлж байна. Ийм чухал зүйл яагаад Өгөөдэй хааны зарлигт хасагдав гэдэг сонин байна. Өгөөдэй хааны үед, хэшиг орж буй хүнийг таних тэмдэг, халалцах ёс горим мөн байсан л байж таараадаа.

1. (Чингис хааны зарлиг) Хэвтүүл шөнө орд орчин хэвтэж (IX-229-19) үүдэн дарж байгсад хэвтүүл шөнө орохун (IX-229-20)

араныг эхид ану далбар, мөрөс ану буутал (IX-229-21) цавчиж огоородхун (IX-229-22).

2. (Өгөөдэй хааны зарлиг) Олон (XII-278-12) тархсаны хойно хоногсад хэвтүүлээс бусад дотогш (XII-278-13) зорчин





бусад нь тохирч байна.

1. (Чингис хааны зарлиг) тэр хэшиг огоорсон хэшигтийг гурван бэрээс сөөтүгэй (IX-227-13,14)

ᠲᠡᠷ ᠬᠡᠰᠢᠭ ᠣᠭᠣᠷᠰᠣᠨ ᠬᠡᠰᠢᠭᠲᠢᠢᠭ ᠭᠤᠷᠪᠠᠨ ᠪᠡᠷᠡᠭᠡᠰ ᠰᠡᠭᠡᠲᠦᠭᠡᠢ

2. (Өгөөдэй хааны зарлиг) урьд зарлигийн ёсоор гурван бэрээс сөөтүгэй (XII-278-73,74)

ᠤᠷᠦᠳᠤ ᠵᠢᠷᠯᠢᠭᠢᠶᠢᠨ ᠡᠶᠰᠣᠷ ᠭᠤᠷᠪᠠᠨ ᠪᠡᠷᠡᠭᠡᠰ ᠰᠡᠭᠡᠲᠦᠭᠡᠢ

∴ Чингис хааны зарлигт “тэр хэшиг огоорсон хэшигтийг” гэж байхад, Өгөөдэй хааны зарлигт энэ хэллэг байхгүй, “урьд зарлигийн ёсоор” гэсэн байна. Бусад нь таарч байна. Эндээс үзэхэд, “урьд зарлиг” тухайлбал, Чингис хааны зарлиг бичгээр тэмдэглэгдэн үлдсэн, Нууц Товчоог зохиождоо түүнд тулгуурласан болох нь маргаангүй байна. “Сөөтүгэй” гэдэг үгийг Чингисийн зарлигт 速亦禿該 sù-yì-tū-kāi ᠰᠡᠭᠡᠲᠦᠭᠡᠢ гэж галигласан бол Өгөөдэй хааны зарлигт 速余禿該 sù-yú-tū-kāi ᠰᠡᠭᠡᠲᠦᠭᠡᠢ гэж хоёр өөр 亦 yì, 余 yú ханзаар галигласан ялгаа байна.

1. (Чингис хааны зарлиг) мөн хэшигт бас нөгөөд хэшиг огоорвоос (IX-227-14,15)

ᠮᠡᠨ ᠬᠡᠰᠢᠭᠲᠢ ᠪᠠᠰ ᠨᠡᠭᠡᠭᠡᠳ ᠬᠡᠰᠢᠭ ᠣᠭᠣᠷᠪᠣᠰ

2. (Өгөөдэй хааны зарлиг) мөн хэшигт хүмүүн бас нөгөөд хэшиг огоорвоос (XII-278-74,75)

ᠮᠡᠨ ᠬᠡᠰᠢᠭᠲᠢ ᠬᠦᠮᠦᠭᠦᠨ ᠪᠠᠰ ᠨᠡᠭᠡᠭᠡᠳ ᠬᠡᠰᠢᠭ ᠣᠭᠣᠷᠪᠣᠰ

∴ Чингис хааны зарлигт “хэшигт” гэдэг үг “хэшигт хүмүүн” гэсэн утгатай байж. Өгөөдэй хааны үед буюу Нууц Товчоог зохиох үед “хэшигт” гэдэг үгийн тодотголлын шинж давамгайл болсон байсан тул ард нь “хүмүүн” гэдэг үгийг нэмж, “хэшигт хүмүүн” болгож тодруулахад хүрчээ. Энэ нь, дундад зууны үеийн монгол хэлний зарим дагаавар, тухайлбал, -и, -ий ᠶᠡ дагааврын хэлзүйн утга, хувьслыг бидэнд харуулсан сайхан жишээ байна. Орчин цагийн монгол хэлнээ –ту,–ту ба –тай –тэй–гийн илтгэх утгын ялгаа нэлээн ойртож байгаа мэт боловч уг утгаа хэвээр хадгалсаар байгааг “морьтын хэшиг явсанд” (морьтой хүний хэшиг явсанд гэдэггүй), “хад сайтын үнэг бардам” (хад сайтай газрын үнэг бардам гэдэггүй) зэрэг олон хэллэгээс харж болно.




1. (Чингис хааны зарлиг) бас мөн хүмүүн бие хад өвчин үгүй (IX-227-15,16)

ᠪᠠᠰ ᠮᠡᠨ ᠬᠦᠮᠦᠭᠦᠨ ᠪᠢᠡ ᠬᠠᠳ ᠥᠪᠴᠢᠨ ᠦᠭᠦᠢ

2. (Өгөөдэй хааны зарлиг) бас мөн хүмүүн өвчин шалтгаа үгүй (XII-278-76)

ᠪᠠᠰ ᠮᠡᠨ ᠬᠦᠮᠦᠭᠦᠨ ᠥᠪᠴᠢᠨ ᠰᠢᠯᠲᠦᠭᠠᠭᠠ ᠦᠭᠦᠢ


∴ Чингис хааны зарлигт “бие хад” (нан.身體<sup>1</sup>合身 мон. ᠪᠢᠡ ᠬᠠᠳ) гэсэн хоршоо үг байгаа ба тэр нь Өгөөдэй хааны зарлигт байхгүй байна. Чингис хааны зарлигт “бие хад өвчин үгүй” гэж (зөвхөн “өвчтэй” бол хэшиг огоорсныг өршөөдөг гэсэн санаа) байхад Өгөөдэй хааны зарлигт “шалтгаа” гэдэг үг нэмснээр утга ба найруулгын томоохон өөрчлөлт оруулжээ (өвчнөөс гадна бусад онц шалтгаан байвал хэшиг огоорсныг өршөөнө гэсэн санаа).





Чингис хааны зарлигт “бие хад” (нан. 身體 合 衮 мон. ) гэдэг хоршоо үг гарч байгаа нь монгол бичгийн дурсгал дахь анхны тохиолдол. “合衮” нь орчин цагийн монгол хэлнээ “бие хаа  ” гэж байдгийн эртний хэлбэр, “хаа  ”-ийн олон тоо бололтой (хөл – хэд, гар – гад зэрэгтэй зэргэцүүлэн үзнэ үү). Нууц Товчоонд ганц л удаа гарна (IX-227-16).

1. (Чингис хааны зарлиг) **хэшигийн ноёд-дур эе үгэхүү (IX-227-16,17)**




2. (Өгөөдэй хааны зарлиг) **хэшигийн өтгүү-дур эе үгүй (XII-278-76,77)**






∴ Чингис хааны зарлигт “ноёд” (нан. 那 牙 衮 мон. ) гэсэн үг байгаа ба Өгөөдэй хааны зарлигт “өтгүү” (“өтгөс” гээгүй, нан. 特 固 衮 мон. ) байна. Чингис хааны зарлигт (эе) “үгэхүү, нан. 兀 格 兀 мон. ”, Өгөөдэй хааны зарлигт (эе) “үгүй (нан. 兀 該 мон. )” хэмээсэн нь Чингис хааны зарлигт “үгүй” гэдэг үгийн арай эртний хэлбэр тэмдэглэгдсэнийг харуулна.

1. (Чингис хааны зарлиг) **бас мөн хэшигт гурвант хэшиг огоорвоос (IX-227-17)**




2. (Өгөөдэй хааны зарлиг) **гутгаарт хэшиг огоорвоос (XII-278-77)**




∴ Чингис хааны зарлигт “бас мөн хэшиг” гэсэн байхад, Өгөөдэй хааны зарлигт хасагджээ. Чингис хааны зарлигт “гурвант” (нан. 忽 兒 班 塔 мон. ) гэж байхад, Өгөөдэй хааны зарлигт “гутгаарт” (нан. 忽 塔 阿 兒 塔 мон. ) гэсэн нь утгын нарийн ялгаатай.


1. (Чингис хааны зарлиг) **гучиндолоон бэрээс сөөд, бидэн-дур явахуйбээн бэрхшээн ажгуу (IX-227-18,19)**



2. (Өгөөдэй хааны зарлиг) **бидэн-дур явахуй-ээн бэрхшээн ажгуу (XII-278-78)**










1. (Чингис хааны зарлиг) **эчнээ хол газраа илээ (IX-227-19)**




2. (Өгөөдэй хааны зарлиг) **гучиндолоон бэрээс сөөд хол газраа нүдний эчнээ илээ (XII-278-78,79)**



∴ Чингис хааны зарлигт “Гучиндолоон бэрээс сөөөд (  жанчаад, нан. 莎尔都(部) ” гэсэн хэллэг “бидэн–дүр явахуйбээн бэрхшээн ажгуу ” гэдэг хэллэгийнхээ өмнө байхад, Өгөөдэй хааны зарлигт хойно нь оржээ. Чингис хааны зарлигт “эчнээ хол газраа (газарт) илээ” гэсэн байхад, Өгөөдэй хааны зарлигт “хол газраа (газарт) нүдний эчнээ илээ” хэмээжээ. Энд, үгсийн байр солигдсоноос гадна, Чингис хааны зарлигт буй “эчнээ” гэдэг үгийн утгыг тодруулж “нүдний” гэдэг үг нэмж найруулжээ. Гэхдээ энэ хэллэг Чингис хааны өөр нэг зарлигт бийг эш татвал : “Бидэнд хэшиг оруулдахун аран, бидний дэргэд явахуйбаан бэрхшээвээс, бусыг оруулж, тэр хүмүүнийг эрүүлж, нүдний эчнээ хол газраа илээ” (224–41) гэжээ. Нууц Товчоог зохиохдоо, урьд нэгэнт бичиж тэмдэглэсэн зүйлийг хуулбарлахдаа ижил утгатай зүйлсээс эхнийхийг авах, мөн, тухайн цагийн ойлголтод таагуулан хоёрдмол утгыг хасах буюу үгсийн утгын нарийн ялгааг гаргахдаа Чингис хааны зарлигийн цар хүрээ, үндсэн санаанаас төдийлөн хальж гараагүй аж. Чингис хааны зарлигт “явахуй–бээн”, Өгөөдэй хааны зарлигт “явахуй–ээн” хэмээсэн нь, нангиад галигт “–бээн” ийг  –ээр, “–ээн” ийг  –ээр тус тус өөрөөр галиглагдийн учир юм.


Өгөөдэй хааны зарлигийн энэ хэсэгт, Чингис хааны зарлигт байхгүй “Бас хэшигүүдийн өтгөс хэшиглэсэн хэшигтнийг үл бүгтгэн хэшиг ороорвоос хэшигүүдийн өтгөсийг эрүүлэе” гэсэн өгүүлбэр нэмэгдсэн мэт харагдавч (278–80), бас тийм биш. Чингис хааны “Хэшиг орруун, хэшигийн ноён өөртөө хэшиглэсгэд хэшигтнийг бүгтгэж, хэшиг орж, гурван хонолдож, егүүтгэлдмүгэй” гэсэн зарлиг нэгэнт буй (227–12). Нууц Товчоонд “бүрэн болгох, бүрдүүлэх, бөөгнөрүүлэх, бүртгэх” гэсэн утгатай, монгол хэлний “бүгд” гэсэн үгтэй язгуур нэг  (172–1),  (227–11),  (208–39),  (96–14, 104–10),

 (278–81) гэсэн 1 үг, 4 хэлбэр буй.


1. (Чингис хааны зарлиг) Энэ зарлиг хэшигтнээ сонсгодхун (IX–227–21)



2. (Өгөөдэй хааны зарлиг) Энэ зарлиг хэшигтнээ сонсготугай (XII–278–83,84)



∴ Энэ хэсэгт Чингис хааны зарлиг ба Өгөөдэй хааны зарлигийн үг таарч байгаа боловч, дагаврын зөрөөтэй байгаа нь анхаарал татна. Чингис хааны зарлигт “соносгох” гэдэг үгнээ үйлийн тийн ялгалын “–дхун” дагавар залгаж “соносходхун” гэсэн байхад, Өгөөдэй хааны зарлигт түүнийг “–тугай” дагавраар сольсон нь жир зүйл биш. Энэ нь, 13–р зууны эхэн үе буюу 1206 оны Барс жил орчмын монгол бичгийн хэл ба 13–р зууны дунд үе, тухайлбал, Нууц Товчоо зохиох үеийн монгол бичгийн хэлний хувьсал ялгааг харуулсан чухаг жишээ. 13–р зууны эхэн үед, үйлийн тийн ялгалд “–дхун” дагавар идэвхитэй хэрэглэгдэж байсан бол, 13–р зууны дунд үе гэхэд баахан хуучирч, “–тугай” дагаварт байраа тавьж өгч байсны гэрч. Мөн тэр цагт заахын тийн ялгалын тэг хэлбэрийг дэлгэр хэрэглэдэг байж. Жишээ нь, “энэ зарлиг хэшигтнээ сонсгодхун (сонсготугай)” гэсэн хэллэг болно. Орчин цагийн монгол хэлэнд бол, “энэ зарлигийг хэшигтнээ сонсголугай” гэж хэлбэржүүлнэ. Нийгмийн орчин ба цаг үеэ даган хэл, хэлний бодгаль хэрхэн улиран хувьсдагийг аар саар гэж орхиж гээлгүй, жишээ баримтад тулгуурлан бичихийг хичээнэ.

1. (Чингис хааны зарлиг)  энэ сонсговоос хэшигүүдийн өтгөс алдалтан болтугай

2. (Өгөөдэй хааны зарлиг) Энэ зарлиг хэшигтнээ эс сонсговоос хэшигүүдийн өтгөс алдалтан болтугай.

∴ “энэ зарлиг” гэдэг хэллэгийг нэгэнт дээр дурдсан, ойлгомжтой байсан тул, давтахаас зайлсхийж, хэлний хэмнэл ёсоор Чингис хааны зарлигт хассан байсныг Өгөөдэй хааны зарлигт “энэ зарлиг хэшигтнээ” гэсэн хэллэг нэмж, утгыг улам тодотгожээ (227–22, 278–87)

1. (Чингис хааны зарлиг) Зарлиг сонсоод, бүрэн давбаас, зарлигийн ёсоор (IX–227–23,24)

2. (Өгөөдэй хааны зарлиг) Зарлиг сонсоод, бүрэн (XII–278–84)

1. (Чингис хааны зарлиг) хэшиг огоорвоос, хэшигтэн алдалтан болтугай (IX–227–24,25)

2. (Өгөөдэй хааны зарлиг) хэшигтэн хэшиг огоорвоос зарлигийн ёсоор эрүүлээ ээ (XII–278–85,86)

∴ Энэ хэсэгт, Чингис хааны зарлиг ба Өгөөдэй хааны зарлиг нэлээн зөрөөтэй байна. Чингис хааны зарлигт “давбаас” (зарлиг зөрчөөс) гэсэн үг байгаа ба “хэшигтэн алдалтан болтугай” гэж хэшиг огоорсон хүнийг алдалтан (хэрэгтэн,буруутан) болгох талаас нь бичсэн бол, Өгөөдэй хааны зарлигт “давбаас” гэдэг үг байхгүй, “хэшигтэн”, “эрүүлээ” гэсэн үгс нэмж, хэшиг огоорсон хүнийг шийтгэх тал руу нь хандуулж бичжээ. Чингис хааны зарлигт “зарлиг сонсоод, бүрэн давбаас, зарлигийн ёсоор, хэшиг огоорвоос, хэшигтэн алдалтай болтугай” хэмээсний дотор “зарлигийн ёсоор” гэдэг хэллэг “хэшиг огоорвоос” гэдэг хэллэгтэй холбоогүй, “хэшигтэн алдалтан болтугай” гэсэн хэллэгтэй холбогдож, “зарлиг ёсоор хэшигтэн алдалтан болтугай” гэсэн санааг илэрхийлж байгаа мөртөө, “хэшиг огоорвоос” гэдэг хэллэгийн өмнө орсныг бид хэт өдгөөчлөн буруутгаж болохгүй. Тэр цагийн найруулгад нь өгсөж очиж тайлбарлах ёстой. Тодотгож буй зүйлээсээ нэлээд хөндий, урд ордог ёс дэлгэр байсныг “зүтгаар зүтгаар” гэдэг тодотголын тухай дээр нэгэнт өгүүлсэн. Харин Өгөөдэй хааны зарлигт “зарлигийн ёсоор” гэдэг хэллэгийг “эрүүлээ” гэдэгтэй нь ойртуулан холбож “зарлигийн ёсоор эрүүлээ” (эрүүдэж шийтгээ) гэжээ. Энэ нь мөн л, 13-р зууны эхэн үеийн монгол хэлний найруулга, дунд үе рүүгээ хэрхэн өөрчлөгдөж байсныг өгүүлж буй сонин баримт.

1. (Чингис хааны зарлиг) надаас эе үгүй бүү ончидутхун (IX–227–27)

2. (Өгөөдэй хааны зарлиг) биднээс эе үгүй, ахлагдав эл хэмээн бүү ончитугай (XII–278–89,90)

∴ Чингис хааны зарлигт “надаас эе үгүй” (миний зөвшөөрөлгүй) гэж, гагцаар төр баригч эзэн хааны үг айлдсан байхад, Өгөөдэй хааны зарлигт “биднээс эе үгүй” болгож найруулсан, “-дхун” дагаврыг “-тугай” болгосон зэрэг зөрөө байна.

1. (Чингис хааны зарлиг) **Заса хөндвөөс над заадхун (IX-227-27,28)**

ᠵᠠᠰᠤ ᠬᠥᠨᠳᠡᠪᠡᠭᠦᠰ ᠨᠠᠳ ᠵᠠᠭᠠᠳᠬᠤᠨ

2. (Өгөөдэй хааны зарлиг) **Засаг хөндвөөс биднээ заатугай (XII-278-90)**

ᠵᠠᠰᠠᠭ ᠬᠥᠨᠳᠡᠪᠡᠭᠦᠰ ᠪᠢᠳᠨᠡᠭᠡ ᠵᠠᠭᠠᠲᠤᠭᠠᠢ

∴ Чингис хааны зарлигт “Заса хөндвөөс” гэж байхад, Өгөөдэй хааны зарлигт “Засаг хөндвөөс” хэмээсэн байна. Энэ нь, 1206 оны Барс жилийн орчим монгол хэлнээ, тухайлбал, Чингис хааны үед “Заса” гэдэг үгийг хэрэглэж байсан ба Нууц Товчоог зохиох үед буюу 13-р зууны дунд үед “Засаг” гэдэг үгийг нь хэрэглэх болсныг бид эндээс мэдэж болно. Өрнө зүгийн зарим хэл, солонгос түүхийн сурвалжид Яаса” (Яса) гэж гардаг нь тэр үеийн “Заса” (“Засаг” биш) гэдэг хэлбэр тархсаныг гэрчилнэ. Нууц Товчооноо “Заса” ийг нангиадаар 札撒 chá-sà гэж галиглаж, “Засаг” ийг 札撒᠎ᠠ chá-sàᠭ гэж тус тус ялгаатай галиглаж, 法度 (хууль, цааз) гэж ижил орчуулсан байна.

Чингис хааны зарлигт “Над заадхун” (надад заагтун, хэлээгтүн) гэж, гагцаар төр мэдэгч эзэн хааны үг айлдсан байхад, Өгөөдэй хааны зарлигт “биднээ заатугай” хэмээн найруулсан,

–дхун ᠳᠬᠤᠨ дагаврыг –тугай ᠲᠤᠭᠠᠢ болгосон байна. Мөн, Чингис хааны зарлигт буй “заадхун ᠵᠠᠭᠠᠳᠬᠤᠨ” гэдэг үгийн эхний үеийг 只 chī- ʅ гээр галигласан бол, Өгөөдэй хааны зарлигийн хэсэгт “заатугай ᠵᠠᠭᠠᠲᠤᠭᠠᠢ” гэдэг үгийн эхний үеийг 札 chá- ʅ гаар галиглажээ. Тиймээс, орчин цагт 札撒᠎ᠠ гэж бичдэг үгийг 只 ʅ-ийг ашиглаж гэж хоёр өөрөөр бичив.

1. (Чингис хааны зарлиг) **Мөхрүүлхүн ёстон бөгөөс бид мөхрүүлү зээ (IX-227-28,29)**

ᠮᠥᠬᠦᠷᠦᠭᠦᠯᠬᠤᠨ ᠢᠶᠠᠰᠤᠨ ᠪᠦᠬᠡᠭᠡᠭᠦᠰ ᠪᠢᠳᠤ ᠮᠥᠬᠦᠷᠦᠭᠦᠯᠤ ᠵᠡᠭᠡ

2. (Өгөөдэй хааны зарлиг) **Үхүүлдэх ёст бөгөөс бид мөхрүүлэд зээ (XII-278-90,91)**

ᠦᠬᠦᠭᠦᠯᠳᠡᠬᠡ ᠢᠶᠠᠰᠤᠨ ᠪᠦᠬᠡᠭᠡᠭᠦᠰ ᠪᠢᠳᠤ ᠮᠥᠬᠦᠷᠦᠭᠦᠯᠡᠳᠡ ᠵᠡᠭᠡ

∴ Чингис хааны зарлигт ∇ Өгөөдэй хааны зарлигт ∇

“мөхрүүлхүн” ᠮᠥᠬᠦᠷᠦᠭᠦᠯᠬᠤᠨ гэж байхад

“үхүүлдэх” ᠦᠬᠦᠭᠦᠯᠳᠡᠬᠡ

“ёстон” ᠢᠶᠠᠰᠤᠨ гэж байхад,

“ёст” ᠢᠶᠠᠰᠤ

–хүн, –хун ᠬᠤᠨ хэрэглэсэн бол,

–дх ᠳᠬᠤ (үхүүлдэх) дагавартай,

–ү (ᠦ мөхрүүлү) хэрэглэсэн бол,

–д (мөхрүүлэд ᠮᠥᠬᠦᠷᠦᠭᠦᠯᠡᠳᠡ) дагавараар сольсон нь, 1206 оны Барс

жилийн орчим монгол хэлнээ, тухайлбал, Чингис хааны үед хэрэглэж байсан үг, дагавар нөхцөлийн зүйл

Нууц Товчоог зохиох үед буюу 13-р зууны дунд үед хэрхэн хувьссаныг батлах тодорхой баримт болов.

1. (Чингис хааны зарлиг) **Няшигдахун ёстон бөгөөс хэвтүүлж нясад зээ (IX-227-29,30)**

ᠨᠢᠶᠠᠰᠢᠭᠢᠳᠠᠬᠤᠨ ᠢᠶᠠᠰᠤᠨ ᠪᠦᠬᠡᠭᠡᠭᠦᠰ ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠵᠢ ᠨᠢᠶᠠᠰᠠᠳᠤ ᠵᠡᠭᠡ

2. (Өгөөдэй хааны зарлиг) **Гэсгээгдэх ёст бөгөөс бид сөөд зээ (XII-278-91,92)**

ᠭᠡᠰᠢᠭᠡᠭᠡᠭᠢᠳᠡᠬᠡ ᠢᠶᠠᠰᠤᠨ ᠪᠦᠬᠡᠭᠡᠭᠦᠰ ᠪᠢᠳᠤ ᠰᠡᠭᠡᠳᠤ ᠵᠡᠭᠡ

∇ Чингис хааны зарлиг ∇

“няшигдахун” гэж байхад

“ёстон” гэж байхад,

“хэвтүүлж” гэж байхад,

“нясад зээ” гэж байхад,

“хун” ( 𐰺 𐰽 няшигдахун) энэ үг байхгүй байхад, дагавар орсон бол,

∇ Өгөөдэй хааны зарлиг ∇

“гэсгээгдэх”

“ёст”

энэ үг байхгүй

“сөөд зээ”

“бид” гэсэн үг нэмсэн.

“дэх” ( 𐰺 𐰽 гэсгээгдэх) дагавартай байгаа нь,

өмнө өгүүлснийг давхар баталж өгөв. Мөн, Монголын Нууц Товчоонд (227–30), (240–19),

(227–29), (199–31) гэсэн нэг үг дөрвөн хэлбэрээр гардаг. Түүнийг “жанчих” гэсэн утгаар ойлгож ирсэн. Хоёр хааны зарлигийг зэргэцүүлэн үзэх явцад эдгээр нь “гэсгээх” гэсэн утгатай болох нь тодорч, жанчих гэсгээдэг гэсэн утгаараа дүйж байна.

[4] Одоо, хэвтүүлийн эрх дархын тухайт Чингис хааны зарлиг ба Өгөөдэй хааны зарлигийг дэлгэрэнгүй зэргэцүүлэн үзье. Эндээс бид, Нууц Товчоонд гардаг үйл явдлууд ямар нэгэн бичмэл эхтэй байсныг ухаж мэдэхийн зэрэгцээ, хориодхон жилийн дараа Чингисийн зарлигийг засч өөрчлөх эрх бүхүй, Нууц Товчооны зохиогч хэн байж болох вэ гэсэн үүд хаалгыг нээж ч юу магад.

1. (Чингис хааны зарлиг) Хэвтүүлээс дээр суурь хэнбээр бүү суутугай (IX–229–25).

2. (Өгөөдэй хааны зарлиг) Хэвтүүлийн суурины дээр хэнбээр бүү суутугай (XII–278–28,29)

∇ Хүмүүсийн суудлыг тодруулж, хэвтүүл хамгийн дээд суудалд суух тухай хоёр их хааны зарлигийн утга ижил боловч үгийн хэлбэр ба найруулгын бага зэрэг ялгаа, бусад заалтын цаана наана орсон байдал ажиглагдаж байна. Энд “хэвтүүл” гэдэг нь “хэв сахиулагч” гэсэн утгаар оржээ. Хэвтүүлийг өөрсөдөө хамгийн ойр суулгадаг нь итгэлт хүмүүсээр биеэ хүрээлүүлж, аливаа аюулаас сэргийлэн хамгаалуулж буй явдал.

1. (Чингис хааны зарлиг) Хэвтүүлээс хэлэн үгүй хэнбээр бүү ортугай (IX–229–26)

2. (Өгөөдэй хааны зарлиг) орд гэрт орох гарахыг Хонхордай, Ширахантан засуул (XII–278–17,18)

хэвтүүллүгээ хамт застугай (XII–278–19)

∇ Чингис хааны зарлигт гаднын хүн дотогш нэвтрэн орох журмын тухай л өгүүлсэн байхад, Өгөөдэй хааны зарлигт тухайн хүн орохоос гадна, засуул ба хэвтүүлийн хамт гарч байхаар заасан нь орд гэрт гаднын хүн үлдэж хоцрохоос сэргэмжилсэн нарийн учиртай. Чингис хааны үед орд гэрт орж гарахыг хэвтүүлд даагаад

байсан бол, Өгөөдэй хааны үед орд гэрт орж гарахыг засуул голлон хариуцдаг болжээ.

1. (Чингис хааны зарлиг) Хэвтүүлийн дээхүн хэнбээр бүү явтугай (IX-229-26,27)

ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠢᠯᠢᠨ ᠳᠡᠭᠡᠬᠦᠨ ᠬᠡᠨᠪᠡᠭᠡᠷ ᠪᠦᠶᠡᠳᠦᠭᠠᠢ

2. (Өгөөдэй хааны зарлиг) Хэвтүүлийн суурин дээхүн бүү явтугай (XII-278-23,24)

ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠢᠯᠢᠨ ᠰᠤᠭᠤᠷᠢᠨ ᠳᠡᠭᠡᠬᠦᠨ ᠪᠦᠶᠡᠳᠦᠭᠠᠢ

∴ Чингис хааны зарлигт “хэнбээр (хэн ч) бүү явтугай” гэсэн байхад, Өгөөдэй хааны зарлигт “хэнбээр” гэдэг үг хасагджээ, Чингис хааны зарлигт шууд л “хэвтүүлийн дээхүн” гэж залгасан байхад, Өгөөдэй хааны зарлигт “хэвтүүлийн суурин дээхүн” гэж “суурин” гэсэн үг нэмэгджээ.

1. (Чингис хааны зарлиг) Хэвтүүлийн захагун бүү явтугай (IX-229-27,28)

ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠢᠯᠢᠨ ᠵᠢᠬᠠᠭᠤᠨ ᠪᠦᠶᠡᠳᠦᠭᠠᠢ

2. (Өгөөдэй хааны зарлиг) Хэвтүүлийн захагун бүү явтугай (XII-278-24)

ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠢᠯᠢᠨ ᠵᠢᠬᠠᠭᠤᠨ ᠪᠦᠶᠡᠳᠦᠭᠠᠢ

∴ Хоёр хааны зарлигийн утга адилхан байна. Харин Нууц Товчооны 札, 合 誼 гэдэг үгийг “захаун, захагун” гэж галиглахаас аргагүй. Энэ нь, ᠬᠣᠶᠢᠭᠤᠷ (хойгуур), ᠤᠷᠳᠤᠭᠤᠷ (урдуур), ᠡᠮᠨᠢᠭᠤᠷ (өмнүүр), ᠬᠠᠵᠢᠭᠤᠭᠠᠷ (хажуугаар) гэдэгтэй төст дагавар залгаж, “захаар” гэхийг ᠵᠢᠬᠠᠭᠤᠨ захагун, захагуур гэж бичдэг байсныг хадгалж үлдсэн сонин хэлбэр. Мөн, “ᠳᠡᠭᠡᠭᠦᠷ” гэхийг “ᠳᠡᠭᠡᠬᠦᠨ” хэмээснийг дараах жишээнээс нэхэн үз.

1. (Чингис хааны зарлиг) Хэвтүүлийн тоо бүү асагтугай (IX-229-28)

ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠢᠯᠢᠨ ᠲᠣ᠎ᠠ ᠪᠦᠶᠡᠳᠦᠭᠠᠢ

2. (Өгөөдэй хааны зарлиг) Хэвтүүлийн тоо бүү асагтугай (XII-278-23)

ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠢᠯᠢᠨ ᠲᠣ᠎ᠠ ᠪᠦᠶᠡᠳᠦᠭᠠᠢ

∴ Хоёр хааны зарлигийн утга адилхан байна. Орчин цагийн монгол хэлний “асуутугай” гэдэг үгийг дундад зууны монгол хэлнээ “асагтугай” хэмээдэг байсан. Нууц Товчооны нангиад галигт “-г”-ийн ард ямар нэгэн эгшиггүй, ᠮᠡ ээр төгссөн битүү үг байна. Жишээ олон.

1. (Чингис хааны зарлиг) Хэвтүүлийн дээхүн явахун араныг хэвтүүл барьтугуй (IX-229-28,29)

ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠢᠯᠢᠨ ᠳᠡᠭᠡᠬᠦᠨ ᠶᠢᠶᠠᠬᠤᠨ ᠠᠷᠠᠨᠢᠭᠢ ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯ ᠪᠠᠷᠢᠶᠡᠳᠦᠭᠠᠢ

Захагун явахун араныг хэвтүүл барьтугай (IX-229-29,30)

ᠵᠢᠬᠠᠭᠤᠨ ᠶᠢᠶᠠᠬᠤᠨ ᠠᠷᠠᠨᠢᠭᠢ ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯ ᠪᠠᠷᠢᠶᠡᠳᠦᠭᠠᠢ

Тоо асуусан хүмүүний хэвтүүл тэр хүмүүний

ᠲᠡᠷᠬᠦᠭᠦ ᠡᠳᠢᠷᠢᠶᠢᠨ ᠤᠨᠠᠰᠠᠨ ᠠᠭᠲᠤ ᠡᠮᠡᠭᠡᠯᠲᠤ ᠬᠠᠳᠠᠷᠲᠢᠭᠢᠭᠢ ᠡᠮᠰᠡᠨ

ᠲᠡᠷᠬᠦᠭᠦ ᠡᠳᠢᠷᠢᠶᠢᠨ ᠤᠨᠠᠰᠠᠨ ᠠᠭᠲᠤ ᠡᠮᠡᠭᠡᠯᠲᠤ ᠬᠠᠳᠠᠷᠲᠢᠭᠢᠭᠢ ᠡᠮᠰᠡᠨ



хувцсан сэлт хэвтүүл автугай (IX-229-30,31,32,33)

ᠬᠤᠪᠴᠢᠰᠢᠨ ᠰᠡᠯᠲᠤ ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠤ᠎ᠠ ᠠᠪᠲᠤᠭᠠᠢ

2. (Өгөөдэй хааны зарлиг) Хэвтүүлийн дээхүн явахун захиан явахун араныг

ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠢᠯᠢᠨ ᠳᠡᠭᠦᠬᠦᠨ ᠶᠠᠬᠠᠬᠦᠨ ᠵᠢᠬᠢᠬᠠᠨ ᠶᠠᠬᠠᠬᠦᠨ ᠠᠷᠠᠨᠢᠭᠢ

хэвтүүл барьтугай.

ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠢᠯᠢᠨ ᠪᠠᠷᠢᠶᠲᠦᠭᠠᠢ

Хэвтүүлийн тоо асагах хүмүүний тэр өдрийн унасан агт

ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠢᠯᠢᠨ ᠲᠣ᠎ᠠ ᠠᠰᠠᠭᠠᠬᠤ ᠬᠦᠮᠦᠭᠦᠨᠢ ᠲᠡᠷ ᠡᠳᠢᠷᠢᠨ ᠤᠨᠠᠰᠠᠨ ᠠᠭᠲᠤ

эмээлт хадаартыг өмссөн хувцсан сэлт хэвтүүл автугай (XII-278-24,25,26,27,28)

ᠡᠮᠡᠭᠡᠯᠲᠤ ᠬᠠᠳᠠᠭᠠᠷᠲᠢᠭᠢ ᠡᠮᠦᠰᠦᠨ ᠬᠤᠪᠴᠢᠰᠢᠨ ᠰᠡᠯᠲᠤ ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠤ᠎ᠠ ᠠᠪᠲᠤᠭᠠᠢ

∴ Хоёр хааны зарлигийн агуулга адил байна. Харин, Чингис хааны зарлигийн нэг, хоёрдугаар мөрийг Өгөөдэй хааны зарлигт "Хэвтүүлийн дээхүн явахун, захиан явахун араныг хэвтүүл барьтугай" гэж нэгтгэн нэг өгүүлбэр болгосон нь хэлний хэмнэлийн зарчмыг харуулсан сайхан жишээ. Мөн, Нууц Товчооны зохиогч Чингис хааны бичмэл зарлигийг харж байгаад бүтээлдээ оруулсан, бас Чингис хааны зарлигийн үг үсгийг өөрчлөх эрх дарх бүхүй хүн байсан, түүнээс гадна, хэл найруулгыг засахаас аөхуулаад Нууц Товчоог зохиох ажилд их анхаарал төвлөрүүлсэн нь илт байна.

Чингис хааны зарлигт "асуусан 阿蘇三" гэж байхад, Өгөөдэй хааны зарлигт "асгах 阿撒三" гэсэн "хадартыг 合答兒禿宜" гэж байхад, "хадартыг 合答兒禿宜" гэж байхад,

гэж урт –аа–тай бичжээ. "Хадар" гэдэг нь орчин цагийн монгол хэлний "хазаар" гэсэн үг бөгөөд дундад зууны монгол хэлнээ тийм хэлбэртэй байжээ. 1206 оны орчмын монгол хэлнээ "Хадар" гэсэн богино байсан эгшиг дөчөөдхөн жилийн дараа буюу 1240 оны орчимд "хадар" гэсэн урт эгшиг болсон нь бидний анхаарууштай үзэгдэл. "эмээлт хадарт" ийн "т" ийг 禿 гэж галигласан байх ба "эмээлт хадартыг" гэсэн нь "эмээлтэй нь, хазаартай нь" (юу байгаагий нь) гэсэн утга. Хэвтүүлийн тоо бол нууц зүйл. Түүнийг сонирхож, мэдэх нь хамгаалалтын нууцад нэвтрэх хэмээсэн болох тул ихэд болгоомжилдог, сэрэмжилдэг байж. Тийм үйлдэл хийгчийг барьсан хэвтүүлийг дээрх мэт биет зүйлээр шууд урамшуулан шагнадаг байсан нь хэвтүүлүүдийн урмыг бадрааж, харууцлагыг дээшлүүлэх чухал арга хэмжээ байсан нь маргаангүй. Тэр үед эмээлт хазаарт морь, хуецас хунар гэдэг бол ховор нандин эд. Одоо цагт машинаар шагнуулахтай тэнцэх зүйл.

Чингис хааны зарлигт, "хэвтүүл" гэдэг үг хоёртаа гарсан тул түүнийг товчилж "Тоо асуусан хүнийг" гэсэн байхад, Өгөөдэй хааны зарлигт "хэвтүүлийн тоо" гэж чухалчлан нэмж тодруулжээ.

1. (Чингис хааны зарлиг) Бидний бие цэрэг эс гарваас хэвтүүл биднээс ангид цэрэг бүү гартугай (X-233-1,2).

ᠪᠢᠳᠨᠢᠶᠢᠨ ᠪᠢᠶᠡ ᠴᠡᠷᠭᠡ ᠡᠰ ᠭᠠᠷᠪᠠᠭᠠᠰ ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠤ᠎ᠠ ᠪᠢᠳᠨᠡᠰ ᠠᠨᠭᠢᠳᠤ ᠴᠡᠷᠭᠡ ᠪᠦᠦ ᠭᠠᠷᠲᠦᠭᠠᠢ

Ийн хэмээгүүлээд зарлиг давж хэвтүүлийг найтаж цэрэг гаргахун цэрэг мэдэх чэрбин

ᠢᠶᠢᠨ ᠬᠡᠮᠡᠭᠡᠭᠦᠯᠡᠭᠡᠳᠤ ᠵᠠᠷᠢᠯᠢᠭ ᠳᠠᠪᠵᠢ ᠬᠡᠪᠲᠦᠭᠦᠯᠢᠭᠢᠭᠢ ᠨᠠᠶᠢᠲᠠᠵᠢ ᠴᠡᠷᠭᠡ ᠭᠠᠷᠭᠠᠬᠠᠨ ᠴᠡᠷᠭᠡ ᠮᠡᠳᠡᠬᠤ ᠴᠡᠷᠪᠢᠨ

алдалтан болтугай. Хэвтүүлийн цэрэг хэр(хэн) үл гаргагдамуй хэмээмүй зээ та

хэвтүүл-лү минь алтан амин сахимуй. Шувуулан авлан явахуйд зоволдмуй. Орд  
хадгалууддаж нүүхүйд өрөгт тэрэг асармуй. Миний бие сахиж хонох хялбаруу  
буй. Гэр тэргэн их аураг нүүхүйд суухуйд асарахуй хялбаруу буй. Тийн давхар хагас  
хагас явдалтан хэмээж биднээс ангид өөр цэрэг бүү явтугай  
хэмээхүй тийм буй заа (X-233-1,2,3,4,5,6,7,8,9,10,11,12,13,14)

2. (Өгөөдэй хааны зарлиг) Бидний бие цэрэг эс гарваас биднээс ангид өөр хэвтүүл цэрэг бүү  
гартугай (XII-278-33,34)

Хоёр хааны зарлигт агуулгын их ялгаа гарах. Хэвтүүлийг өөрснөөсөө ангид цэрэгт явуулахгүй учир шалтгааныг Чингис хааны зарлигт маш тодорхой заасан байгаа бол, Өгөөдэй хааны зарлигт үгүй байна. Чингис хааны зарлигт “Хэвтүүл” гэдэг үг “биднээс ангид” (тусдаа) гэдгийнхээ өмнө байгаа ба харин Өгөөдэй хааны зарлигт хойш татаж аваачсанаас гадна, “өөр” гэсэн үг нэмж “ангид өөр” (тусдаа) болгон найруулж хүч нэмэгдүүлсэн байна.

Энэ мэт, Чингис хаан 1206 оны орчим тунхагласан зарлигууд ба Өгөөдэй хаан ширээ залгамжлаад тунхагласан зарлигуудыг үг үсэгчлэн тулгаж, дундад зууны эхэн үеийн монгол бичгийн хэл ба 13-р зууны дунд үе буюу Нууц Товчоо зохиох үеийн монгол бичгийн хэлний хэвшинж, хувьсал өөрчлөлт, үгийн сан, хэлзүй, найруулгын зарим асуудлыг хөндөж, ялгаа заагийг тодруулав. Утга адил буюу ойролцоо зарлигуудыг зэргэцүүлэн үзсэн болно.

Чингис хааны сэрүүн тунгалаг ахуйд тэмдэглэсэн зүйлсийн найруулга, дагавар нөхцөл зэрэг нь Өгөөдэй хааны буюу Нууц Товчоог туурвин гаргах тэр цаг үеийнхээс нэлээн ялгаатай болсон байсныг бид дээрх жишээнүүдээс тодорхой мэдэж болохоос гадна, дундад зууны монгол хэлний хөгжил

03. Монголын Нууц Товчооны зохиогч хэн байж болох вэ?

Энэ бол, олон жилийн өмнөөс, Нууц Товчоо судлаачдын анхаарлын төвд байсан, өдгөөг хүртэл хүн бүрийг гижгэдсээр байгаа асуудал. Эрдэмтэд янз бүрийн хүний нэрийг дэвшүүлж байлаа. Юу юуны

духанд хүрэлгүй зохиогчийн нэрийг таахаас зайсаж, тал талын түүхэн баримт, нөхцөл байдал, он цаг, бичигтэн мэргэдийн хүрээн дотор шахан оруулж, хэн дээр тулахыг нь үзвээс зохистой.

Энэ удаа, Нууц Товчооны хэлийг судалж, хэлний хэрэглэгдэхүүн, түүний дотроос Чингис хааны зарлиг ба Өгөөдэй хааны зарлиг, олонт тохиолдох үг хэллэгийн зэргэцүүлсэн судалгаанд тулгуурлан, тухайлбал, Нууц Товчоо өөрийнх нь эд эс, махбод, ухаан сэтгэлгээнийх нь амин хүрээн дотор шунгаж, зохиогчийг тодруулахыг хичээлээ, үүнд:

Нэгдүгээрт, Чингисийн зарлигийг Хөх дэвтэрт бичсэн хүн хэн билээ? – Шиги Хутугу билээ.

Чингис хааны нэгэн онцгой зарлигийг энд нэхэн сануулж эш татвал :

“Гур иргэний хувь хувилсныг, зарга гаргалсныг Хөх дэвтэр бичиг бичиж дэвтэрлэж, ургийн ургаа хүртэл,

Шиги Хутугу–гийн надур зетэж ёслож, Хөх бичиг цагаан цаалсанд дэвтэрлэснийг бүү егүүтгэтүгэй.

Егүүтгэхүн аран алдалтан болтугай”

хэмээсэн байдаг (VII-203-39).

32

Хоёрдугаарт, Чингис хааныг тэнгэрт хальсны дараахан, үе залгамж нь холдож сунжраагүй, Чингис хаантай хамтран зүтгэгсэд, төр засаг, бичиг соёл, цэрэг эрдмийн их мэргэд сэрүүн тунгалаг асан цагт, хаан ширээ шууд залгасан Өгөөдэй хааны үед Чингис хааны зарлигт хэн гар хүрч болох вэ? Юуч атугай, Нууц Товчоо зохиогч тун их эрх дархтай, Чингис хааны зарлигт гар хүрэх мэдэлтэй, гар хүрлээ гээд алдалтан (хэрэгтэн) болохгүй (дээрх зарлигт өгүүлснийг үз) тийм хүн байсан байна. Тийнхүү, Чингисийн зарлигийн үг үсгийг өөрчлөх, найруулгыг засах эрх бүхүй бөгөөд, итгэлтэн бөгөөд, зүрх зоригтон хэн байж болох вэ? Шиги Хутугу бус уу.

Хэл соёл, хэв хууль, ёс заншил, зан суртхуун, түүх бичлэгийн ямар салбарт хэр зэрэг нөлөө бүхүй засвар, өөрчлөлтийг Чингис хааны зарлигт оруулсан болохыг тодруулбал, Нууц Товчоо зохиогчийн билиг оюун, бодол ухаан, боловсрол мэдлэг, өвөрмөц төрх, чадвар чансаа, цар хүрээний тухай бидэнд нэгийг хэлж, хоёрыг санагдуулах учиртай. Иймээс, чухам ямар засвар, өөрчлөлт оруулж вэ гэдгийг нэг дор оруулан товчлон цэгцлэж, сэтгэлд хоногшуулан, өнгө өөсийг (аясыг) тухайлан авч үзвээс зохистой хэдий ч, дээр нэгэнт бодот жишээтэйгээр өгүүлсэн тул энд товчлоё.

Энэ мэт, Чингис хаан 1206 оны орчим тунхагласан зарлигууд ба Өгөөдэй хаан ширээ залгамжлаад тунхагласан зарлигуудыг үг үсэгчлэн тулгаж, дундад зууны эхэн үеийн монгол бичгийн хэл ба 13-р зууны дунд үе буюу Нууц Товчоо зохиох үеийн монгол бичгийн хэлний хэвшинж, хувьсал өөрчлөлт, үгийн сан, хэлзүй, найруулгын зарим асуудлыг хөндөж, ялгаа заагийг тодруулан үзэхэд, ийм цар хүрээний засвар, өөрчлөлт хийх хувь тавиланг Шиги Хутугу–д түүх заяасан болов уу даа гэсэн бодол төрнө.

*Гураедугаарт*, Чингис хааны Их Засаг хуулийг Хөх дэвтэрт мөнхөлсөн, Чингис хааны “үзэхийн нүдэн, сонсохын чихэн болсон” (203–27), Чингисийн “зургадугаар дүү” (203–22), Төрийн Их заргач түшмэл (203–36) Шиги Хутугу–г амьд сэрүүн ахуйд, Чингис хаантай “зетэлдэж бичсэн” (203–39) түүний зарлигийг хэн засч зүрхлэх вэ? Хэн ч бус, Шиги Хутугу өөрөө л тийм эрхтэй буй заа.

*Дөрөвдүгээрт*, Өгөөдэй хаан “Би дөрвөн үйлс буруу болжухуй” (201–30,31) хэмээн, хамаа бус хүнд долоон булчирхайгаа тоочоод, хаан хүн өөрөө өөрийгөө зэмлээд сууж байх болов уу даа.

Тэмүүжин ба, Чингис хаан ба, ордны үйл явдлыг өчүүхнээс авхуулаад нууц, далд зүйлсийг хүртэл мэдэж бичих хүн хэн байв? Цөөн хүний нэг нь – Шиги Хутугу яах ч аргагүй мөн.

*Тавдугаарт*, Өгөөдэй хааны өгүүлснийг Нууц Товчоонд тэмдэглэн оруулах тийм зүрх зоригтон

Шиги Хутугу–аас өөр хэн байх болдоо. Чингис хааныг амьд сэрүүн ахуйд нь, чухам зарлигаа айлдаж байхад нь Чингис хааны өөдөөс омог бардам өчиж байсан ганц хүн хэнсэн билээ гэдгийг нэхэн санацгаая. “Боорж, Мухалитан хэнээс илүү тус хийлээ! Хэнээс илүү хүч өглөө! Соёрхол өгдөхүй ээ, би юун дутуу тус эс боллоо. Юун дутуу хүч эс өглөө, би. Өдгөө надад ямар соёрхол өгмүү” гээд, Боорж, Мухалитаныг дуудахгүй зогсож байсан, тийм зоригт бичгийн хүн бол Шиги Хутугу билээ.

*Зургадугаарт*, Өгөөдэй хаан, Шиги Хутугу–г амьд сэрүүн ахуйд өөр хүнд Нууц Товчоог зохио гэж зарлиг буулгах болов уу даа. Үгүй л байх аа даа.

*Долдугаарт*, Чингис хааны үед бичиж тэмдэглэсэн зүйлс ба Өгөөдэй хааны үед бичиж тэмдэглэсэн зүйлс агуулга адил боловч хоорондоо үг үсэг, дагавар нөхцөлийн талаар зөрөөтэй, үг хэллэг, өгүүлбэр нь хойно урдаа орсон, найруулгын талын ялгаа гарч байгаа нь 13–р зууны эхэн үе буюу 1206 оны Барс жил орчмын(түүнээс ч өмнөх үеийн) монгол бичгийн хэл ба 13–р зууны дунд үе, тухайлбал, Нууц Товчоо зохиох үеийн монгол бичгийн хэлний өөрчлөлт хувьслыг харуулсан ховор нандин баримт мөн боловч, Өгөөдэй хааны үед бичиж тэмдэглэсэн зүйлс нь Чингис хаан ба Шиги Хутугу хоёрын зетэлдэж (203–39) бичиж үлдээсэн тэрхүү зарлиг цаазын цар хүрээ, өнгө өөс, дүртөрхөөс хальж гараадүй байна. Энэ нь Нууц Товчооны зохиогч Шиги Хутугу гэдгийг давхар батлан харуулж байна бус уу. Ийнхүү, хэл соёл, түүхэн баримт, Нууц Товчоо өөрт нь дулдуйдан, Монголын Нууц Товчоог зохиох түүхэн тавилан Шиги Хутугу–д ногдсон болов уу даа хэмээн цохон тэмдэглэв. Мэргэд тунгаатугай.

### Тамганаа шингэсэн монгол ухаан

Б.Сумьяабаатар (Монгол)

Тамга бол эрх дарх, сүр хүч, билиг оюун, төр ёсны бэлгэдэл. Тамгагүй төр, төргүй тамга гэж байсангүй.

Хүннү-гийн Шаньюйн тамга "Наран саран нивэлт Хүннү-гийн Их Шаньюй" гэсэн үгтэй байжээ. Энэ бол огторгуйн бэлгэдэл, Монголчууд буурал эртнээс төр ёс, хувь заяагаа гараг ертөнцтэй холбож байсны гэрч. Олоо болтол, манай юманд нар, сар яваад байдаг чинь ийм нарвйн учиртай... Монгол төрийн алтан жолоо тасралгүй яв явсаар оноо бидний үед хүрч ирснийг тамгаар нь баталж чулуун хөшөө босгох болсныг хэн хүнгүй амьсгаа даран хүлээж байлаа. Гэтэл, харахаас нүд хальтрам, бодохоос дотор харлам тийм хэдэн зүйл үүсчээ. Үүнд,

- Зоосыг ар, өвөр хоёр талаас нь үзүүлдэг шиг, тамгыг нүүрэн ба бөөрөн талаас нь ихэрлүүлэн харуулдаг. Нүүрнээсээ бичээс нь, бөөрнөөсөө тамганы тэмдэг ил байдаг. Нүүрний бичээс нааш харж байхад, тамганы тэмдэг дээр нь байвал, хажуу тал дээрээ нштэй тамга шиг үзэгдэх тул урлагийн бүтээлд ч аль болох тийн үзүүлэхээс зайлсхийдэг.
- Юугаар бүтээсэн, юу гэж бичсэн, хэмжээ дамжаа, хэлбэр галбираас тамганы зэрэг дэв тодрохоос гадна, тамганы тэмдэг маш нарийн учир холбогдолтой. Тамганы тэмдэг гэж, тамганы ишнээ сийлсэн дүрсийг хэлнэ. Барс сийлсэн бол Барс тэмдэгт тамга, Арслан сийлсэн бол Арслан тэмдэгт тамга, Луу сийлсэн бол Луу тэмдэгт тамга гэх жишээтэй. Нүүрний үсгийг уншихаас урьтаж, баруулыг нь хармагц л, эзэн хаан, эх хатан, бичгийн сайд, цэргийн түшмэл, харьяа улсын вангаас авхуулаад хэний тамга болох нь танигдана.
- Төрийн ордны хойт талд босгосон "Монгол Төрийн Тамганы хөшөө"ний ишин дээр Бар сийлсэн байна. Будлианы эх үүсвэр энд байна. Энэ бол нүдний булангаар, чихний хажуугаар, дүлий дөмбөн царайлаад өнгөрүүлж хэрхэвч болохгүй асуудал. Тамганы хөшөөний загварыг гаргахдаа ул суурьтай судалгаа хийгээгүй, эрдэмтэн мэргэд олон түмнийхээ санал бодлыг аваагүй буюу хэрэгсээгүй, төрийн тамганы тухай дулимагхан ойлголттой, хайнга хандсанаас ийм байдалд хүрсэн бололтой. Энэ нь цаанаа, оноогийн Монгол Төрийн тамганы ишнээ арслан сийлснийг буруу гэсэн бодол цухалзуулж, үе үеийн монгол төрийн тамгануудын баруулыг бараар сольж өөрчлөвөөс зохистой гэсэн санаа агуулж хөшөөг босгосон шиг болжээ. "Өнөөдөр" сонинь сурвалжлагч *"Тамганы барил бар байгаа нь ямар учиртай вэ. Одоогийн манай төрийн тамганы барилд арслан сийлсэн байдаг шүү дээ?"* гэж тун ухаалаг санаа өгч асуухад, хөшөөний загвар зохлон бүтээгч: *"Цогт тайжс кинон дээр Лилдэн хаан тамгаа нууцж байгаа хэсэг гардаг. Тэр тамга бар барилтай байсан. Ер нь монголчууд барын дүрсийг төрийн тамганы барилдаа сийлж байсан уламжлалтай"* (Өнөөдөр сонин. 2006.11.27. Даваа) гэж харуулжээ. Дундад зуун, түүнээс урагших Монгол Төрийн тамга олоогүй байгаа нөхцөлд *"Монголчууд барын дүрсийг төрийнхөө тамганы барилд сийлж байсан уламжлал"*тай гэж хэлж болохгүй шүү дээ. Уран сайхны бүтээл, тухайлбал, кинонд барс барилтай хийсэн үзэгддэг. Уран сэтгэмж заавал бодот үнэнтэй тохирч байх албагүй, мөн тэр нь, одоогоос бүхэл бүтэн нэг жарны өмнөх явдал хэмээн түүнийг уучлах нэгэн учиг бий. Энэ хооронд шинжлэх ухаан урагш явж өгсөн байна. 1940-өөд оны үед сураггүй байсан маш их мэдээ сэлт нэгэнт илэрч, 21-р зууны үед босгож буй "Монгол Төрийн Тамганы хөшөөг" бүтээхдээ харгалзан үзэж, бодож ашиглууштай мэдээ занги туйлаас олон байлаа. Одоогийн шинжлэх ухааны хүрсэн дээд түвшингээс эргэн харж, харахан олоодгүй байгаа 13-р зууны Монгол гүрний төрийн тамга ямар байсныг тосөөлөн, чухам тэр үнэнтэй тун ойртуулан үйлдвээс зохистой, тухайлбал, Их Монгол Улсын Төрийн тамганы үгийг Гүюг хааны хэмээн алдаршсан тамганы бичээсийн дардаст дуудуйдахаас өөр аргагүй. Гэвч, тун ноцтой бөгөөд зайлшгүй залруулаас зохих хэдэн зүйл байгааг онцлон тэмдэглэе.
- 1) Монголын дөрвийн дөрвөн төрийн тамганы дардасыг хэвээр буулгаад, дээр нь Бар барилд хийсэн байгаа нь яав ч зөвтгөшгүй. Нэн ялангуяа бид, Төрийн тамгаа хөшөө чулуунаа хэзгэй буруу сийлэн мөнхөлж, хойч үеэлд үлдээвэл хожим гэмшээд гэмшээд, наманчлаад наманчлаад үл нимгэрэх нүгэл болно.

2) Богд хааны нэг тамга Арслан бариултай байсаар атал яахаараа энэ хөшөөнөө Бар бариултай болгон сийлдэг байна? Энэ  
3) Одоо, Монгол Улсын Төрийн тамга Арслан бариултай байсаар атал яахаараа энэ хөшөөнөө Бар бариултай болгон сийлдэг байна? Энэ бол, Монгол Улсын Үндсэн Хуулийг зөрчсөн явдал. Үүнд, Монгол Улсын Үндсэн Хуулийн нэгдүгээр бүлгийн 12-р зүйлийн 6-рт “Монгол Улсын Төрийн тамга ... арслангийн дүрс бүхий бариултай байна” (1992 он.7-р тал) гэж тов тодорхой зааж хуульчилсан байна. Хөшөө бэлгэдлийн чанартай урлагийн бүтээл гэх буюу, нэг кинонд тийм байсан гэх буюу, музейд бар бариултай тамга олон байдаг гэдгээр халхавч хийж ( Энэ баримт чинь л төрийн тамгыг бар бариултай хийж болохгүй эгдийг хэлж өгч байна шуу дээ, Төрийн тамга олон байх учиргүй.) Болот үнэнээс хазайж, Төрийнхөө тамгануудаар тоглож, Үндсэн Хуульн зөрчиж хэрхэвч болохгүй мэт санагдана. Тэгвэл, ямар бариултай хийх ёстой вэ?

Лав л Барс бариултай байж таарахгүй гэдгийг дараах баримтаар баттай нотлан хэлж болно.

- Сүүл үеийн Х а н хүний тамга олдоод байгаа. Тэр нь Бар бариултай. Түүнийг яг дуурайн, олдоогүй байгаа Х а а н хүний тамгыг бүтээж болохгүй. Олдоогүй байгаа нь ертөнцөд ганц хувь, хосгүй онцгой тамга. Өөрөөр хэлбэл, Хаан хүний тамга, жирийн нэг Хан хүний тамгатай адил болчихжээ гэсэн үг. Хаан хүн, хан хүнтэй ижил тамгатай байх нь ёсонд хазгай.
- Их Монгол Улсын Төрийн тамга харьяа улсынхтайгаа ив ижил буюу хос байх ёсгүй, байгаа ч үгүй нь хэн бүхнээ тодорхой бөгөөд Түүхэн баримт үүнийг гэрчилнэ, тухайлбал: 1260 онд Хубилай хаанаас Гуулин улс (Солонгос)ын ванд "Барсын тэмдэгт улсын (төрийн) вангийн тамга" хүртээсэн байдаг тухай Гуулин улсын сударын 25-р дэвтрээс эш татвал:

Эртний солонгос	⇨	虎	符	國	王	之	印
Солонгос дуудлага	⇨	호	부	국	왕	지	인
Нангиад дуудлага	⇨	hū-	fū-	guó-	wáng-	zhī-	yin
Монгол орчуулга	⇨	барс тэмдэг улс ван гийн тамга болно.					

- Нөгөө талаар, барс бол Төрийн тамганд залрах төдийлөн хүндтэй амьтан биш. Барс тэмдгийг Түмний ноёд ч хүртээж байсан байдаг. Үүнд, 1281 оны өвлийн 10 сарын шарагчин гахай өдөр Юаны хааны (Хубилайн) зарлигаар Гуулин улсад (солонгост) Түмтийн Газар (Фү 府) байгуулж Их жанжин Түмтийн ноён Иньхү (印侯 印侯)д Барс тэмдэг тамга хүртээж байсныг Гуулин улсын сударын 29-р дэвтрээс эш татвал:

Эртний солонгос	⇨	賜	虎	符	及	印	張
Солонгос дуудлага	⇨	사	호	부	국	인	장
Нангиад дуудлага	⇨	si-	hū-	fū-	ji-	yin-	zhāng
Монгол орчуулга	⇨	хүртээв Барс тэмдэг хийгээд тамга болно.					

Мөн, саяхан болтол, манжийн үед гэхэд л "Б а р с малгай" (барсын толгой дүрсэлсэн малгай)г Ногоон тугийн цэргийн ард (энгийн цэрэг) өмсдөг (Г-03941):

"Б а р с хормогч" (барсын арьсыг дүрслэн хийсэн хормогчийг) Ногоон тугийн цэргийн ард (энгийн цэрэг) өмсдөг (Г-03943):

"Б а р с дээл" (барсын арьсыг дүрслэн хийсэн хувцас)ийг Ногоон тугийн цэргийн ард (энгийн цэрэг) өмсдөг (Г-03942) байсан.

Ийнхүү, буруу юм хийвэл (Цогт тайж киноны тэр хэсэг ч тэр) хойч үедээ ямар балагтайг өнөө цагийнхан биеэр амслаа. Төрийн тамга бол, зөвхөн урлагийн бүтээл ч биш. Дор дороо нарийн утга учиртай, бие биенээс нь салангид үзэж болдоггүй тийм эд эсийн бүхэл бүтэн цогцос юм.

Иймд, санахаас зүрх шимшрэм эл эндүүрлийг бага дээр нь (үг нь хөшөөг нээж дэлхий дэхинд зарлахаасаа өмнө зассан бол юутай сайн байв) засан залруулах нь зүйд иийцнэ хэмээн бодож, төр засаг, түмэн олноо ухааны мэлмийд толилуулав.